


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-18 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **1146** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1110 тохиолдлын 94% /1077/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /69/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5+1/, Төв/16/, Дорноговь /2/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 319 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **18** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.04.27 – 05.03)

2025 оны эпидемиологийн 18 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **36** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс болон сүүлийн 5 жилийн дунджаас тус тус 33%-иар өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-18 дугаар долоо хоногт** нийт **327** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


163Эмнэлгийн
тусламж авч буцсан**164**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 18 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **16** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 48%-аар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 50%-аар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 18 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	4	4
2	Эмийн хордлого	12	0	12
Нийт		12	4	16

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд 25%-ийг эрэгтэй, 75% -ийг эмэгтэй хүмүүс эзэлж байгаа бөгөөд 18-аас 48 насныхан байна. **Санамсаргүйгээр** өртсөн тохиолдлуудыг шалтгаанаар авч үзвэл белизна, аяга таваг угаагч шингэн зэрэг ахуйн болон цэвэрлэгээний зориулалттай бүтээгдэхүүн болон бензин, машины үнэртүүлэгч зэрэг машин, техникийн зориулалттай бүтээгдэхүүнүүдэд хордсон байна.